

Эрүүл мэндийн газрын хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилт

2023 оны IV сар

Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ
ЗГ-ын тогтоол					
6	11	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2022-12-28 Дугаар 2022_488	5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Эрүүл мэндийн газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын цалин батлагдсан сүлжээний дагуу нэмсэн. Төсөв санхүүжилт Эрүүл мэндийн яамнаас ирдэг учир орон нутгийн 10 хувийн нэмэгдэл нэмэгдээгүй байна.	70
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
12	17	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэл аймгийн хэмжээний нийт хүн амын 30 хувийг хамруулахаар төлөвлөөд ажиллаж байна. 2023 оны 4 дүгээр сард 0-5 насны багцад 1371 , 6-17 насны багцад 1542, 18 дээш насны 4 багцад 356 иргэн, нийт 3269 хүн хамрагдаад байна. Энэ нь аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 0-5 насны багцын үзлэгт 6283 хүүхэд хамрагдахаас 3192 хүүхэд хамрагдаж хамрагдалт 50,9%, 6-17 насны багцын үзлэгт 10338 хүүхэд хамрагдахаас 7744 хүүхэд хамрагдаж хамрагдалт 74,9%, 18-аас дээш насны багцын үзлэгт 30578 хүн хамрагдахаас 5493 хүн хамрагдаж, хамрагдалт 18,0%-д тус тус хүрсэн.	70